



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ103-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (3)

**Хэт хөнгөн агаарын хөлөг -
Үйл ажиллагааны дүрэм**

2022 оны 12 сарын 9

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Зорилго

Энэхүү АС нь ИНД-103-ын дагуу хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг биелүүлэх зааварчилгаа, зөвлөгөөгөөр хангахад оршино.

Холбогдох дүрмүүд

Энэхүү АС нь ялангуяа ИНД-103-тай харилцан хамааралтай болно.

Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын ИНД-ийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн МУ-ын ИНБД-ийг боловсруулсан.

АС103-1-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

АС103-1-ийг NZ АС103-1-ийн 2012 оны 11 сарын 09-ний өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

1 Ерөнхий зүйл.....	3
2 Дүрмийн нийцэл.....	4
4 Бүлэг E - Үйл ажиллагааны дүрэм.....	4
5 Бүлэг F - Нислэгийн дүрэм.....	6
6 Бүлэг G - НТЧ болон техник үйлчилгээ	6
ХАВСРАЛТ 1 Дүйцэх Загварын Стандарт	12

1 Ерөнхий зүйл

Энэхүү АС-ыг хянан зассан энэ удаагийн гол зорилго нь хэт хөнгөн агаарын хөлгийн тодорхойлолтод байгаа бага моментийн үзүүлэлтийг хянан үзэх явдал юм. Зөвшөөрөгдөх бүх максимум жинг нэмэгдүүлэхийн тулд бага моментийн үзүүлэлтийг дараах байдлаар хянан өөрчилсөн:

- (1) усан гадаргуу дээр буухаар тоноглогдоогүй агаарын хөлгийн хувьд 600кг; болон
- (2) усан гадаргуу дээр буухаар тоноглогдсон агаарын хөлгийн хувьд 650кг.

Хянан зассан өөрчлөлт нь Монгол Улсын стандартыг Австрали зэрэг хэт хөнгөн агаарын хөлгийг үйлдвэрлэн нийлүүлэгч гадаадын орны дүйцэх стандартад нийцүүлж байгаа болно. Энэ АС нь хамгийн сүүлд 2000 онд хянагдан засагдсан бөгөөд тухайн үед хэт хөнгөн агаарын хөлгийн ашиглалттай холбоотой бүх зааварчилгаа материалыг хамруулан оруулж чадаагүй байсан. Хэт хөнгөн агаарын хөлгийн тодорхойлолттой хамаатуулан бага моментийн үзүүлэлтийг хянан засаж сайжруулахад одоо байгаа зааварчилгаа материалыг хянан үзэх шаардлагатай болсон. Үр дүнд нь ИНД-103-тай холбоотой энэхүү АС-д зааварчилгаа материалыг Бүлэг 2-т нэмж орууллаа:

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт хэт хөнгөн агаарын хөлгийг тодорхойлолтыг дараах байдлаар давтан харуулбал:

Хэт хөнгөн агаарын хөлөг гэж Даргын хүлээн зөвшөөрөхүйц бага моментийн үзүүлэлттэй, хоёроос дээшгүй хүн тээвэрлэхээр зохион бүтээсэн нислэгийн бага үндсэн үзүүлэлттэй агаарын хөлгийг.

Дараах техникийн үзүүлэлтийг, хэт хөнгөн агаарын хөлгийн тодорхойлолттой нийцэж байгаа тул хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж тодорхойлно:

Энэхүү АС-ын Хавсралт 1-д жагсаасан маягийн загварын стандартад тусгасан хэт хөнгөн агаарын хөлгийн аливаа техникийн үзүүлэлт, эсхүл

Нэг, эсхүл хоёр суудалтай, хамгийн их нислэгийн жинтэйгээр суултад орохдоо агаарт тэнцвэртэй байх хамгийн бага хурд нь 83 км/цаг-аас (45 Knots) ихгүй ба хамгийн их жин нь дараахаас хэтрэхгүй агаарын хөлөг:

- хоёр суудалтай, газар дээрээс хөөрч буудаг агаарын хөлгийн хувьд 600кг, эсхүл
- хоёр суудалтай, усан дээрээс хөөрч буудаг, эсхүл газар уснаа буугч агаарын хөлгийн хувьд 650кг, эсхүл
- ганц суудалтай, газар дээрээс хөөрч буудаг агаарын хөлгийн хувьд 510кг, эсхүл
- ганц суудалтай, усан дээрээс хөөрч буудаг, эсхүл газар уснаа буугч агаарын хөлгийн хувьд 550кг.

2 Дүрмийн нийцэл

Энэхүү АС-ээр зөвхөн зааварчилгаа болон хүлээн зөвшөөрөгдөхүйц өгөгдөл шаарддаг хэм хэмжээг нарийвчлан авч үзсэн болно.

ЗМ 103.5(а)(1) Нисгэгчид тавих шаардлага

Энэ зүйлд заасан хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэхийг ИНД-149-ийн дагуу нисэх клубын гэрчилгээ эзэмшигч олгоно. ИНД-103-т тусгайлан заагаагүй боловч хоёр жилийн нислэгийн дүгнэлтийг нисгэгчийн үнэмлэх олгосон ИНД-149-ийн байгууллагын үйл ажиллагааны журмын дагуу хийлгэх шаардлагатай. Нисгэгч нь агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээсээ өмнө хоёр жилийн нислэгийн дүгнэлт хийлгэх хэрэгтэй. Гадаадын хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэх эзэмшиж байгаа нисгэгч нь өөрийн туршлагад үнэлгээ хийлгэхээр ИНД-149-ийн байгууллагад хандах ба хэрэв хангалттай сайн гэж үнэлэгдвэл Монгол Улсын хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэх авч болно.

Тэмдэглэл:

Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэхийг ICAO-д хүлээн зөвшөөрдөггүй тул дүйцэх байдлыг тогтоолгохгүйгээр гадаадын улсад ашиглаж чадахгүй бөгөөд тухайн улсаас хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчийн үнэмлэх авна.

ЗМ 103.7(2)(ii) Нислэгийн зааварчилгаа

Хэт хөнгөн агаарын хөлгийг жолоодох ур чадвараа хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчид шалгуулах шаардлагатай. Хэт хөнгөн агаарын хөлгийн Сургагч-нисгэгчид шалгуулах шаардлагын зорилго нь ИНД-61-ийн дагуу сургагчийн зэрэглэл авсан этгээд нь маш бага моменттой агаарын хөлгийн жолоодлого, удирдлагын онцлог шинж чанаруудтай танил бөгөөд мэддэг болохыг харуулах явдал юм.

4 Бүлэг Е - Үйл ажиллагааны дүрэм

ЗМ 103.101 Бүртгэл

Энэ зүйл нь бүртгэлийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчаас тухайн агаарын хөлөг ИНД-ийн нэр томъёоны тайлбарт заасан хэт хөнгөн агаарын хөлгийн тодорхойлолтыг хангаж байгааг нотлох баримт гаргаж өгөхийг шаардана. Тухайн агаарын хөлөг нь 103.207(а)(1)(ii)-д заасан агаарын хөлгийн маягийн загварын стандартыг хангаж байгааг нотлох баримтаар харуулснаар үүнийг хангах болно. Хүсэлт гаргагч нь дээрх мэдээллээр хангах үүрэгтэй. Тухайн загвар болон гэрчилгээжүүлэлтийн үндсэн дэлгэрэнгүй мэдээллийг ИНЕГ-ын өгөгдлийн санд оруулснаар бүртгэлийн гэрчилгээ олгох боломжтой тул хангалтгүй мэдээлэл нь бүртгэлийг удаашруулах болно.

Энэ нь ялангуяа, бүртгэл хийгдсэнээс хойш ИНЕГ-аас тухайн агаарын хөлөгтэй ямар ч холбоотой байдаггүй тул Ангилал 1-д хамаарах хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд маш чухал юм. ИНЕГ нь эрхийг баталгаажуулах тодорхой мэдээлэлтэй байх ёстой.

Үүнийг үйлдвэрлэгчээс хэвлэн гаргасан тайлбар материал, эсхүл цахим хуудас зэрэг эрх бүхий эх үүсвэрээс авч болно.

Өөр нэг арга зам нь тухайн агаарын хөлгийг бусад танигдсан үндэсний НТЧ-ын эрх бүхий байгууллагаар бүртгэлийн гэрчилгээний маягтад хүлээн зөвшөөрсөн болохыг нотлох баримт байж болно.

ЗМ 103.103 Агаарын хөлгийн нислэгийн заавар

Хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдээс агаарын хөлгийн нислэгийн зааварт заасан үйл ажиллагааны хязгаарлалтын дагуу тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг шаардахгүй. Энэ нь анх журам гаргаж байх үеийн хялбар хийцтэй, бага үзүүлэлттэй энгийн хэт хөнгөн агаарын хөлөгт тохирч байсан. Зарим хэт хөнгөн агаарын хөлөг нь өнөө үед хураагддаг газардах анги, харьцангуй нарийн төвөгтэй систем болон бүхэлдээ өндөр үзүүлэлт бүхий бүхэлд нь сайжруулсан агаарын хөлөг болсон байна. Үйлдвэрлэгч тухайн агаарын хөлөгт зориулсан нислэгийн дэлгэрэнгүй зааврыг гаргаж болно. Нисгэгч энэ баримт бичгийг ашиглах үед тохирч байхыг ИНЕГ-аас анхаарна.

Хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл нь *"Энэ хэт хөнгөн агаарын хөлөг үйлдвэрлэгчийн заасан аливаа хязгаарлалтын дагуу үйл ажиллагаа гүйцэтгэнэ"* гэсэн стандарт тодорхойлолтыг багтаана. Иймд, нисгэгч үйлдвэрлэгчийн нислэгийн зааварт заасан хязгаарлалтыг ашиглах ба дагаж мөрдөнө мөн хязгаарлалтын талаарх бүх зурагт хуудас болон тэмдэглэгээ байрлуулсныг бататгана.

ЗМ 103.105(а) Бүхээгт авч явах баримт бичиг

Хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь нислэгийн зааврыг авч явах шаардлагагүй. АС103.103-т зориулсан зааварчилгаа материалд заасантай ижил шалтгаанаар, үйлдвэрлэгчээс агаарын хөлөгтэй хамт нийлүүлсэн нислэгийн заавар/баримт бичгийг агаарын хөлгийн бүхээгт авч явах болон нислэгийн үед ашиглах боломжтой байлгахыг хатуу зөвлөж байна.

ЗМ 103.107 Зурагт хуудас

Энд шаардсан зурагт хуудас нь уншихад хялбар байх бөгөөд энэ нь эрс тэс өнгөтэй, суудалд байгаа нисгэгч уншиж чадахаар байх ёстой.

Загвар, эсхүл гэрчилгээжсэн нийт жин (эдгээрээс хамгийн багийг нь) болон ашигт ачааллын максимум болон минимум хэмжээг үйлдвэрлэгчээс нийлүүлсэн загварын тодорхойлолт, эсхүл нислэгийн заавраас гаргаж авна. Үйлдвэрлэгчээс гүйцэтгэсэн агаарын хөлгийн жин болон төвлөрөлтийн тооцооллоос хойш нэмэлт төхөөрөмж нэмсэн бол ашигт ачааллыг үнэн зөв тодорхойлохын тулд хоосон жинг шинээр тогтооно. Энэ ашигт ачааллыг АС103.107(а)(2)-д шаардсан Зурагт хуудсыг гаргахад ашиглана.

5 Бүлэг F - Нислэгийн дүрэм

3М 103.151 Түлшний шаардлага

Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчээс 30 минутын нөөц түлштэй үйл ажиллагаа гүйцэтгэхийг шаардахгүй. Энэ нь анх журам гаргаж байх үеийн хялбар хийцтэй, бага үзүүлэлттэй энгийн хэт хөнгөн агаарын хөлөгт тохирч байсан. Орчин үеийн хэт хөнгөн агаарын хөлгийн зарим төрөл нь олон цаг агаарт байж улс орныг хөндлөн нисэж чадах чадвартай болжээ. Агаарын хөлгийн энэ төрлийн хувьд үйл ажиллагаа эрхлэгч нь 91.305(a)-гийн шаардлагыг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

3М 103.153 Минимум өндөр

Хэдийгээр ИНД-91.311-д агаарын хөлөг VFR-ээр 150м-ээс (500 ft) нам өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглодог ч, энэ зүйл нь хэт хөнгөн агаарын хөлөг 150м-ээс (500 ft) нам өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрнө. Дахин хэлэхэд энэ нь бага үзүүлэлт болон жинтэй эхний үеийн загварын хэт хөнгөн агаарын хөлөгт зориулан гаргасан зөвлөмж байсан. Илүү орчин үеийн өндөр үзүүлэлттэй хэт хөнгөн агаарын хөлөг нь энгийн хайрцаг/тойрог өндөр рүү хурдан өндөр авч чадна. Өндөр үзүүлэлттэй хэт хөнгөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь 150м-ээс (500 ft) нам өндөрт үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хатуу зөвлөж байна.

103.155 Нислэгийн шалгуур

103.155(b)(2)(i)-ийн зорилгоор, дүйцэх шалгалт гэдэг нь ИНД-149-ийн хүрээнд эрх олгосон байгууллагаас тэдэнд олгосон гэрчилгээний хүрээнд авч байгаа шалгалтыг хэлнэ.

103.159 Зорчигч тээвэрлэх

103.159(4) нь энэ зүйлд заасан шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд нисгэгч хэт хөнгөн агаарын хөлгөөр хүн тээвэрлэхийг хориглодог. Нэг шаардлага нь агаарын хөлөг 103.213-ын дагуу холбогдох техник үйлчилгээний бүртгэлд бичилт хийж оруулсан НТЧ-ын мэдэгдэлтэй байх. Энэ зүйлд заасан техник үйлчилгээний бүртгэл гэдэг нь ихэвчлэн агаарын хөлгийн их биеийн бүртгэлийн дэвтэр болно. Иймд, нисгэгч зорчигч тээвэрлэхээсээ өмнө агаарын хөлгийн их биеийн бүртгэлийн дэвтэрт НТЧ-ын мэдэгдлийг бичиж оруулсныг шалгаж бататгах үүрэгтэй.

6 Бүлэг G - НТЧ болон техник үйлчилгээ

103.205 Нислэгийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт заасан Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлгийн тодорхойлолтын эерэг тал нь Ангилал-1 нисдэг тэргийг хамруулсанд байна.

103.207 Нислэгийн зөвшөөрөл олгох

Энэ зүйл нь хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл олгоход тавих шаардлагыг заасан. Хүсэлт гаргагч нь дараах 3 бүрдэл хэсэгт хамаарах баримтжуулсан нотлох баримтыг ирүүлнэ:

1. маягийн загварыг хүлээн зөвшөөрсөн;
2. заавал мөрдөх шаардлагын хэрэгжилт; болон
3. тухайн агаарын хөлгийн төлөв байдлын үнэлгээ.

Нөхцөл байдал болгоныг дор илүү дэлгэрэнгүй зааж оруулсан:

НХЗА 103.207(а)(1) (Маягийн Загварыг Хүлээн Зөвшөөрөх)

Энэ зүйл нь Ангилал-2 хэт хөнгөн агаарын хөлөг зарим төрлийн маягийн загварыг хүлээн зөвшөөрсөн баримттай байхыг шаарддаг. Энэ зорилгод дараах 3 арга замаар хүрэх боломжтой юм:

- (1) Хэрэв хэт хөнгөн агаарын хөлөг энэ зүйлд заасан аль нэг гадаад улсын иргэний нисэхийн удирдах газрын НТЧ-ын нарийвчилсан маягийн загварын стандартыг хангаж байгааг харуулсан баримт нотолгоотой бол, хэт хөнгөн агаарын хөлөгт загварын гэрчилгээ, эсхүл дүйцэх баримт бичгийг олгох нь хэт хөнгөн агаарын хөлөг тухайн зүйлд шаардсан маягийн загварын стандартыг хангаж байгааг нотлох хангалттай баримт болно. Түүнчлэн, ийм маягийн загварын шаардлага тавьдаг байсан гадаадын ИНЕГ-аас хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөл олгосноор батлан харуулж болно. Энд заасан дүйцэх баримт бичиг нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц баримт бичиг гэж ойлгох хэрэгтэй.
- (2) Тухайн агаарын хөлгийн маягийн НТЧ-ын түүх нь шаардлага хангасан түвшинд хүрснийг нотлох баримтаар. Энэ нь хэт хөнгөн агаарын хөлгийн хувьд илүү түгээмэл хэрэглэдэг аргачлал, Монгол г.м. олон Улсад хэт хөнгөн агаарын хөлөгт тавих албан ёсны НТЧ-ын гэрчилгээжүүлэлтийн шаардлага байдаггүй. ИНЕГ нь агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс энэ талаар албан ёсны мэдэгдэл гаргана гэж найдаж байгаа ба нөлөө бүхий эх сурвалжаас мэдээний тайлан маягийн албан ёсны мэдэгдлийг хүлээн зөвшөөрч болно.
- (3) Хэрэв энэ зүйлийн (1), эсхүл (2)-т тодорхойлсон аргачлалын алийг ч ашиглах боломжгүй бол, эсхүл нэг удаагийн загвартай тохиолдолд, энэ зүйл нь сонирхогчийн угсарсан агаарын хөлгийн адил төстэй зарчмаар ашиглалтын тест хийлгэн өвөрмөц ганц загварыг хүлээн зөвшөөрөх боломжийг олгож болно. Нислэгийн шалгалтын хугацаа ихэвчлэн хамгийн багадаа 40 цаг байна.

НХЗА 103.207(а)(1)(ii)(D)

Энэ зүйл нь Хэсэг А, В болон С-д заасан маягийн стандарттай дүйцнэ гэж үзсэн маягийн бусад стандартыг хүлээн зөвшөөрөх эрхийг Даргад олгоно. Энэхүү АС Дүйцэх Загварын Стандарт гэж нэрлэсэн Хавсралт 1-д заасан стандарт нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц гэж тооцсон стандартыг агуулна.

ЗМ 103.207(а)(2) (Үндсэн шаардлагууд) (Mandatory Requirements)

Энд шаардсан нөхцөл болзлыг хэвийн үед хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл олгох зорилгоор агаарын хөлөгт үзлэг шалгалт хийх үед хийж хамтруулан үнэлж дүгнэнэ. Хүсэлт гаргагч нь хэрэв ашиглалтад байсан агаарын хөлгийг импортлон оруулж ирж байгаа бол аливаа өмнөх хугацаанд хийгдэж байсан техник

үйлчилгээний нарийвчилсан тайлан баримтыг оролцуулаад агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр болон сэнсний техникийн үзлэг хяналтын иж бүрдэл баримт бичлэгийг бэлэн байлгана. (гадаад орны техникийн үзлэг хяналтын эх баримт дэвтэр хамт бэлэн байвал зохино).

АС 103.207(а)(2)(iii) нь агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл бүрдэл хэсгийн үйлдвэрлэгч нараас зайлшгүй шаардлагатай гэж үзсэн үзлэг шалгалт, эд ангийн солилт, их засвар, техник үйлчилгээг хийх шаардлагыг хангасныг харуулсан мэдэгдэл, тэмдэглэлийг техник үйлчилгээний дэвтэрт бичиж тусгасан байхыг шаардана. Энэхүү мэдээллийг техник үйлчилгээний гарын авлага, нислэгийн заавар, үйлчилгээний бюллетень болон захидлаас харж болно.

ЗМ 103.207(а)(3) (Ганцаарчилсан агаарын хөлгийн байдлыг шалгаж тогтоох) (Individual Aircraft Condition Assessment)

Энэ АС нь хэт хөнгөн агаарын хөлөгт нислэгийн зөвшөөрөл олгохын өмнө шаардагдах үзлэг шалгалтад хамааруулахыг шаардана. Одоо цагт энэхүү үзлэг шалгалтыг зөвхөн ИНЕГ-аас хийх бололцоотой. (ИНЕГ-аас хийх үзлэг шалгалтын өмнө агаарын хөлөг дээр АС 103.217(с)(1)-д заасны дагуу агаарын хөлгийн төлөв байдлын жилийн үзлэг шалгалт хийгдсэн байхыг шаардана). Үзлэг шалгалтын амжилттай үр дүнг тухайн агаарын хөлгийн техникийн баримт бичигт энэхүү зөвлөмжийг заан тэмдэглэл хийнэ.

ЗМ 103.207(b) Нислэгийн түр зөвшөөрөл

Энэ АС нь Монгол Улсад зохион бүтээж, үйлдвэрлэсэн одоогоор хүчинтэй үйлчилж байгаа аль ч стандартад нийцэхгүй байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн хийц загварыг шалгаж тогтоох нислэгт нислэгийн зөвшөөрөл олгоход ашиглагдана. Энэ тохиолдолд хэт хөнгөн агаарын хөлөг нь Англи улсын Иргэний нисэхийн НТЧ-ын шаардлагын Хэсэг “S”-д заасны дагуу далавч ба хөл ангийн туршилтад орж шалгагдсан байх ёстой. Энэ баримт бичгийн хуулбарыг Англи улсын иргэний нисэхийн удирдах газрын Вэб хуудаснаас татан авч болно.

ЗМ 103.207(с) Нислэгийн түр зөвшөөрлийн үйл ажиллагааны хязгаарлалт

Нислэгийн түр зөвшөөрөл нь нислэгийн үйл ажиллагааны тодорхой хязгаарлалтыг агуулах бөгөөд 6 сараас дээшгүй хугацаатай байна. Хязгаарлалт нь дараах зүйлийг хамарч болно:

- Нислэг үйлдэж болох орон зай, талбайг тусгайлан зааж өгөх
- Туршилтын нислэгийг гүйцэтгэх нисгэгчийг нэрлэн заах
- Агаарын хөлгийн хэлбэр, тохиргоог заах
- Гүйцэтгэх ёстой туршин шалгах зүйлийг заах

ЗМ 103.209 Модификаци

Энэ АС нь нислэгийн зөвшөөрөлтэй хэт хөнгөн агаарын хөлөгт түүний НТЧ-т нөлөөлж болох модификаци хийж байгаа үйл ажиллагаа эрхлэгчээс агаарын хөлөг нь АС103.207-ын шаардлагад бүрэн нийцсэн хэвээр байгааг баталгаажуулах үзлэг шалгалтад оруулахыг шаардана. ИНД-149-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллага нь

хийгдсэн модификацийг шалгаж АС103.207-ын шаардлагад бүрэн нийцсэн хэвээр байгаа эсэхийг үнэлж баталгаажуулах чадвартай техникийн мэргэжлийн боловсон хүчинтэй байдаг. Хэрэв үнэлгээ нь хангалттай сайн гэж гарсан бол агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт хийгдсэн модификацийг нарийвчлан тодорхойлж заасан, агаарын хөлөг нь АС103.207-ын шаардлагад бүрэн нийцсэн хэвээр байгааг баталгаажуулсан тэмдэглэл хийж өгнө. АС103.207(3)-ын дагуу шаардсан үзлэг шалгалтыг Дарга хүлээн зөвшөөрсөн этгээд гүйцэтгэнэ.

Энэ нь хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөлд заасан хязгаарлалт болно.

ЗМ 103.211 Ашиглалтын тест хийх

АС(1)-(4)-д заасан агаарын хөлөгт хамаарах зааварчилгааны материалыг дор харууллаа:

- (1) Бэлэн зураг, төлөвлөгөө ашиглаж тухайн этгээд бэлдэц материалыг сонгон авч бүтээсэн агаарын хөлөгт хамаарах;
- (2) Бэлэн зураг, төлөвлөгөө ашигласан боловч бэлдэц материалын иж бүрдлийг нь хүлээн зөвшөөрсөн ханган нийлүүлэгчээс нийлүүлж бүтээсэн агаарын хөлөгт хамаарах;
- (3) Ханган нийлүүлсэн материалаар урьдчилан үйлдвэрлэсэн хэсгүүд бүхий иж бүрдлийг угсрах гарын авлагыг ашиглан бүтээсэн агаарын хөлөгт хамаарах;
- (4) Ямар ч бүтээн босголтын үйл ажиллагаа шаардагдахгүйгээр зөвхөн бэлэн үндсэн бүрдэл хэсгийг угсрах замаар бүтээсэн агаарын хөлөгт хамаарах.

ЗМ 103.213(1) НТЧ-ын мэдэгдэл

Энэ АС нь агаарын хөлгийн ашиглалтын тест хийх нислэг үйлдсэн нисгэгчээс техник үйлчилгээний бүртгэлд нислэгт тэнцэх мэдэгдэл оруулсан байхыг шаардана. Энэ тохиолдолд техник үйлчилгээний бүртгэл гэдгийг агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр гэж ойлгоно.

103.213(1)-д шаардсан нарийвчилсан мэдээлэл нь дараах зүйлийг агуулна:

- гүйцэтгэсэн маневрын жагсаалт (хурдны нуралт, огцом эргэлт, агаарт шумбах нислэг болон аэробатикийн маневр гэх мэт);
- дээрх маневрыг гүйцэтгэсэн хурдны хязгаар;
- турших нислэгийн үеийн агаарын хөлгийн жин;
- турших нислэгийн үеийн агаарын хөлгийн хүндийн хүчний төвлөрлийн хязгаар.

Эдгээр нарийвчилсан мэдээллийг бичиж оруулахад туслах зорилгоор Монголын нисэх клуб дээрх бүх үзүүлэлтийг хамарсан турших нислэгийн хуваарийг боловсруулан гаргасан байна.

ЗМ 103.217 Техник үйлчилгээ болон үзлэг шалгалтын шаардлага

Энэ АС нь Ангилал 1 болон 2 хэт хөнгөн агаарын хөлгийн техникийн үйлчилгээ болон үзлэг шалгалтын шаардлагыг заана.

АС 103.217(а)(1) нь үйл ажиллагаа эрхлэгчээс хэт хөнгөн агаарын хөлгийг нислэгт тэнцэх нөхцөлтэй байлгахыг шаардана. ИНД-ийн нэр томъёоны тайлбарт нислэгт тэнцэх нөхцөл гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна:

Нислэгт тэнцэх нөхцөл гэж зохион бүтээлт, үйлдвэрлэл, техник үйлчилгээ, модификаци, засвар болон нислэгийн аюулгүй байдалтай холбоотой ИНД-д заасан бүх шаардлагыг хангасан, агаарын хөлгийн бүрдэл хэсэг, түлш болон агаарын хөлгийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бусад материал, бодисыг багтаасан агаарын хөлгийн төлөв байдлыг.

АС103.217(а)(2) нь үйл ажиллагаа эрхлэгчээс бүх шаардлагатай НТЧ-ын Удирдамжийг ИНД-39-ийн шаардлагын хүрээнд ханган биелүүлсэн байхыг шаардана. Тохиолдлоор ч биш, ИНД-103-т “Гэрчилгээжсэн агаарын хөлөгт хамаарах” гэж ИНД-91-д байгаатай адил нэг ижил үг үсэг хэрэглэсэн байдаг. Ерөнхийдөө зөвхөн хэт хөнгөн агаарын хөлөгт зориулан гаргасан НТЧ-ын Удирдамжийг агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт бичдэг туршлага байдаг ч олон тохиолдолд ижил төрлийн төхөөрөмж, эсхүл бүрдэл хэсгийг хэт хөнгөн агаарын хөлөгт мөн суурилуулж угсарсан байдгаас хамааран агаарын хөлгийн загварыг нь заагаагүй, олон ерөнхий НТЧ-ын Удирдамжийг хэт хөнгөн агаарын хөлгийн тухайд ч хэрэгжүүлж биелүүлэх шаардлага гардаг.

Орчин үеийн хэт хөнгөн агаарын хөлөг нь шилэн дэлгэц, авто жолоодогч, транспондер, тогтмол хурдтай сэнс, болон хураагддаг газардах анги зэрэг олон стандарт тоноглол, хийц бүрдлийг агуулах болсон учраас ерөнхий НТЧ-ын Удирдамжийг хэт хөнгөн агаарын хөлгийн тоноглол, хийц хэсэгт хамааруулан шалгаж үзэж байх шаардлагатай. НТЧ-ын Удирдамжийг анхлан нягталж үзэхдээ тэднийг бүртгэлийн дэвтрийн холбогдох хэсэгт оруулан тэмдэглэсэн байх аваас дараа нь жилийн төлөв байдлын үзлэг шалгалтын үед гол чухал ажлууд хийгдсэн байж байцаагч, хянагч нарын ажил ч хурдан явагдах болно. Чухал зүйл нь тэднийг анхлан хянаж оруулж байх ажил боловч ИНЕГ-ын мэдээллийн сүлжээний үйлчилгээг авч жагсаалтад оруулан түүнийгээ баяжуулж шинэчилж байх нь илүү оновчтой хялбар байх болно.

АС103.217(а)(3) нь маш ойлгомжтой. Хэвийн үйл ажиллагааны үед гарсан гэмтэл дутагдлыг засаж залруулж байх шаардлагатай. Түүнийг дараагийн үзлэг шалгалт хүртэл хойшлуулж болохгүй.

АС103.217(б) шулуун ойлгогдоно. Орчин үеийн ихэнх хэт хөнгөн агаарын хөлгүүд үйлдвэрлэгчээс үйлчилгээ, техникийн засвар арчилгааны гарын авлага номтой нийлүүлэгддэг. Эдгээр гарын авлага нь шаардлагатай үзлэг шалгалтыг үечлэн тогтоож ямар үед, юуг хийхийг зааж өгсөн байдаг. Хэрэв таны агаарын хөлөг ийм гарын авлага заавартай байгаа бол түүнийг дагаж мөрдөх шаардлагатай.

АС103.217(с) нь өөрөө өөрийгөө тайлбарлах болно. Гэвч чөлөөлсөн хугацаа нь аль эрт өнгөрсөн тул (h)-г үүнээс хойш мөрдөхгүй.

103.217(d), (e) болон (f) нь жилийн төлөв байдлын үзлэг шалгалтыг хийх, гэрчилгээжүүлэх тухай заасан. Гэрчилгээжүүлэлтийг үзлэг шалгалтын маягт дээр нь хийнэ. ИНД-149-ийн дагуух хүчинтэй гэрчилгээтэй байгууллага нь урьдчилан хэвлэж бэлдсэн үзлэг шалгалт хийх, тэдгээрийн үр дүн, болон гэрчилгээжүүлсэн тухай

тэмдэглэх хэсэг бүхий үзлэг хяналтын хуудас, маягтыг холбогдох байцаагч нарт өгч явуулдаг. ИНД-66-ийн дагуу олгосон агаарын хөлөг, хөдөлгүүрийн таарч тохирох зэрэглэл бүхий агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн хүчинтэй үнэмлэхтэй этгээд нь үзлэг хяналтын өөрсдийн тамга, тэмдэгтэй маягт цаастай байдаг. Энэхүү тамга, тэмдэгтэй маягт нь ИНД-149-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагынхтай нэг адил түвшний нарийвчилсан мэдээлэл агуулсан байна.

Жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийсэн этгээдээс үзлэг шалгалтын маягтыг агаарын хөлгийн орох хаалганы дэргэд хөдөлгөөнгүй байрлуулсан байхыг шаардана. Үзлэг шалгалтын маягт нь дараагийн жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хүртэл дээр нь бичигдсэн мэдээлэл хангалттай сайн хадгалагдаж, харагдаж үншигдахуйц байх материалаар хийгдэх ба дараах мэдээллийг агуулсан байна:

- байцаагчийн овог, нэр болон гарын үсэг;
- байцаагчид олгосон зөвшөөрлийн, эсхүл үнэмлэхний дугаар;
- агаарын хөлгийн бүртгэл;
- дараагийн жилийн төлөв байдлын үзлэг шалгалт хийх хугацаа.

Маягт нь (Хэрэв шаардлагатай бол) байцаагчид эрх олгосон байгууллагын нэр хаягтай байна.

ЗМ 103.219 Үйлдвэрлэл

Хэрэв этгээд нь хэт хөнгөн агаарын хөлгийг зааварт тодорхойлсон аливаа материалаар бүтээж байгаа бол түүнийг ИНД-148-ийн шаардлагад нийцсэн байхыг шаардахгүй. Гэвч аливаа этгээд, эсхүл байгууллага нь хэт хөнгөн агаарын хөлгийг зарж борлуулан санхүүгийн ашиг олохоор угсарч, эсхүл үйлдвэрлэж байгаа бол тухайн этгээд, эсхүл байгууллага нь ИНД-148-ын дагуу гэрчилгээжиж болно.

ЗМ 103.221 Хэрэглэл болон төхөөрөмжийн шаардлага

(а)(1)(i)-д заасан маягийн загварын заалт нь 103.207(а)(1)(ii)-д тодорхойлон заасан аль нэг маягийн загварт хамаарах бөгөөд үүгээр уламжлаад тухайн маягийн загварт хамаарахын тулд угсарч суурилуулсан байх шаардлагатай хэрэглэл болон төхөөрөмжийг тодорхойлсон байж болно.

АС103.221(а)(1)(ii) нь дээр (i)-д тодорхойлсон маягийн загварын шаардлагад хамаарахаас бусад зохион бүтээгч, үйлдвэрлэгч нараас нэмэгдэл байдлаар угсарч суурилуулсан хэрэглэл болон төхөөрөмжид хамаарна.

АС103.221(а)(2) - дээрхээс үл хамааран агаарын хурд, нислэгийн өндөр болон бодит соронзон чиглэл заагчтай байх ёстой. Хэрэв хөдөлгүүр үйлдвэрлэгч нь хөдөлгүүрийн ажиллагааг хянах эргэлт, тосны даралт, халуун хүйтэн, бортогоны толгойн халуун хүйтэн, эсхүл хөргөлтийн шингэний халуун хүйтэн, хөдөлгүүрээс гарч байгаа хийн халуун хүйтэн зэргийг хэмжих ёстой гэж заасан бол мөн холбогдох хэрэгслийг угсарч суурилуулсан байх ёстой. Хэрэв агаарын хөлөг нь нисдэг тэрэг бол эдгээр дээр нэмээд хөдөлгүүр болон роторын эргэлтийн заагч хэрэгсэл нэмж угсарсан байна.

ХАВСРАЛТ 1 Дүйцэх Загварын Стандарт

Дараах маягийн загварын стандартыг ИНД-103.207(а)(1)(ii)(D)-ийн дагуу хэт хөнгөн агаарын хөлгийн дүйцэх маягийн загварын стандарт гэж Дарга хүлээн зөвшөөрөхүйц гэж тооцсон болно.

Баримтын нэр:	Гаргасан:
CS-VLA	Европын холбооны агаарын тээврийн тээврийн аюулгүй байдлын агентлаг(EASA)
UL/2 PT2	Чех улсын ИНЕГ
DS 10141E	LAMAC ба Канад улсын тээврийн яам